



ЖАВХЛАНТ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-07-30 № 077-2020/04-НА-04  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Жавхлант сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Жавхлант сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Жавхлант сумын Монгол Ардын намын хорооны Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Жавхлант сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр 1...4..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Жавхлант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Жаргалант

**1. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

- ❖ Хамтын шийдэлтэй, ухаалаг бодлоготой, сайн засаглалыг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжин, хүний ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлнэ.

**1.1. Боловсрол**

- ❖ Боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, хүний хөгжлийн суурь үндэс гэж үзнэ.

1.1.1 Сургуулийн өмнөх боловсролыг бага насны хүүхдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бий болгон бүлэг бүрд стандарт тоглоомын тавиуртай болгоно.

1.1.2 Цэцэрлэгийн “Багш хөгжил” төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

1.1.3 Цэцэрлэгт яслийн бүлэг нэмж ажиллуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

1.1.4 Цэцэрлэгийн багшийн ажлын ур чадварыг сайжруулж, сургалтын үйл ажиллагаагаар хүүхдийг ажиглан судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.1.5 Ерөнхий боловсролын сургуульд өдөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжин, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, төрөл бүрийн дугуйлан хичээллүүлнэ.

1.1.6 Ерөнхий боловсролын сургуулийг байгалийн ухааны цогц лабораторитой болгоно.

1.1.7 Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг, чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилдог болно.

**1.2. Эрүүл мэнд**

- ❖ Иргэн, гэр бүл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэн төлөвшүүлж, эрүүл амьдралын хэв маягийг дэмжинэ.

1.2.1 Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг хувь хүний онцлогт тохируулж урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.2.2 Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.2.3 Сумын эрүүл мэндийн төвийн халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжийг сэргээн засварлана.



## **СЭЛЭНГЭ АЙМАГ ЖАВХЛАНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

- 1.2.4 Сумын эрүүл мэндийн төвийг цусны ерөнхий шинжилгээний болон ЭХО төхөөрөмжөөр хангана.
- 1.2.5 Моргийг тусгай зориулалтын хөргүүртэй болгоно.
- 1.2.6 Эмчилгээ оношилгооны алсын зайн сургалтад шаардлагатай техник хэрэгслээр хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглах боломж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.2.7 Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт багтаан эрүүл амьдралын замналыг эцэг эх олон нийтийн байгууллагуудын оролцоонд тулгуурлан бий болгоно.
- 1.2.8 Сумын хэмжээнд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.
- 1.2.9 Сумын иргэдийг гадаад, дотоодын эмч нарын сайн дурын багийнхны эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.


### **1.3. Соёл урлаг, спорт, хөдөлгөөн эрүүл мэнд**

- 1.3.1 Залуучууд хөгжлийн төв бүхий спортын ордон барих ажлыг холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.3.2 “Эрүүл амьдарцгаая” хөтөлбөрийн хүрээнд сонирхогчдын клубуудийг дэмжин ажиллана.
- 1.3.3 Нийтийн биеийн тамирыг дэмжиж гадна талбайн дасгалын тоног төхөөрөмж суурилуулна.
- 1.3.4 Хүүхэд залуучуудын дунд өвлийн спортын төрлүүдийг дэлгэрүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах мөсөн гулгуурын талбайтай болгоно.
- 1.3.5 Соёлын төвийн хүүхэд залуучуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэхэд шаардлагатай хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмжөөр хангаж, орчныг сайжруулна.
- 1.3.6 Соёлын ажилтнуудын урлагийн хувцасны нөөцийг нэмэгдүүлнэ.

### **1.4. Хүнд ээлтэй амьдрах орчин**

- ❖ Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай таатай орчин бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана.
- 1.4.1 Сумын төвийн ногоон байгууламжийг өргөжүүлж, зам дагуу ногоон зурвасыг нэмэгдүүлнэ.
  - 1.4.2 Хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ байгуулах, үйлчилгээний байгууллагууд болон орон сууцыг холбох ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
  - 1.4.3 Сумын төвд төвлөрсөн халаалтын зуух барих, айл өрхүүдийг дулаанд холбох, байгууллагуудын халаалтыг нэгтгэх ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
  - 1.4.4 Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийг жилд 2-оос доошгүй удаа дарж тэгшлэн, хашаажуулж, аж ахуйн нэгж байгууллага, өрхүүдийн ахуйн хог хаягдлыг тогтмол ачих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
  - 1.4.5 Сумын иргэд болон төрийн үйлчилгээний зарим байгууллагуудын хүнсний худалдан авалтыг сумандаа үйлдвэрлэсэн баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.





## 2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 2.1. Дэд бүтэц

- 2.1.1 Суманд стандартын шаардлага хангасан авто зогсоол байгуулж тохилог эко орчин бүрдүүлнэ.
- 2.1.2 1, 2-р баг тус бүрд мал усалгааны худгийг шинээр гаргаж, сумын төвд хашаандаа мод бут, жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариалж байгаа өрхүүдийн санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 2.1.3 Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.
- 2.1.4 Байнгын ажиллагаатай ахуйн үйлчилгээний төвийг ажиллуулна.
- 2.1.5 Сумын төвөөс хөдөө рүү гарах гол чиглэлүүдийн замыг засах, тэгшлэх, тэмдэгжүүлэх ажлуудыг жил бүр зохион байгуулна.
- 2.1.6 Сумын төвийн хайрган хучилттай замыг хатуу хучилттай зам болгох ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 2.1.7 Сумын төвийн явган хүний зам болон зам дагуу гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.1.8 Хөдөөгийн малчдын үүрэн холбооны сүлжээний хүрээг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 2.1.9 Сумын төвийн хорооллын цахилгааны 04 шугамыг холбогдох байгууллагатай хамтран шинэчлэх ажлыг зохион байгуулна.
- 2.1.10 Сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор “Хашаа” хөтөлбөрийг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

### 2.2 Өрхийн үйлдвэрлэл, дотоод нөөц боломж

- 2.2.1 Үйлдвэрлэл эрхлэгчдийг бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ болон борлуулалтын зах зээлтэй холбох ажлыг зохион байгуулна.
- 2.2.2 Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээлч, бие даасан байдлыг дэмжих зорилгоор “Нэг баг-нэг бүтээгдэхүүн” аяныг өрнүүлнэ.
- 2.2.3 Сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын гаргасан санал санаачилгад дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.4 Иргэд болон залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуй эрхэлж буй иргэдийг холбогдох төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах ажлыг зохион байгуулна.

### 3.1 НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1.1 Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, газар зохион байгуулалт, бэлчээрийг зохистой ашиглан хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор малчдын дундын сан бий болгох ажлыг зохион байгуулна.
- 3.1.2 Хөрс хамгааллын бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.1.3 Бэлчээрийн даацыг тэнцвэржүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.1.4 Цөлжилтийг сааруулах төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.1.5 Эко аялал жуулчлалын баазуудыг бий болгох, ашиглалтад оруулах чиглэлээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын гаргасан санал, санаачилгыг дэмжиж ажиллана.



## СЭЛЭНГЭ АЙМАГ ЖАВХЛАНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

3.1.6 Мал аж ахуйн түүхий эдийг “Дархан” цогцолборт нийлүүлэх болон малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

### 4. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 4.1 Эрчимжсэн аж ахуй

4.1.1 Хүлэмж болон зоорины аж ахуй эрхлэгчдийг “Хураалт-хадгалалт-борлуулалт”-ын сүлжээнд холбох ажлыг дэмжиж ажиллана.

4.1.2 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, чанар ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.3 Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр шимийг тогтмол хүртэх боломж бүрдүүлэх зорилгоор “Нэг сум - нэг хоршоо” төслийн хүрээнд мал нядалгааны цех, ноос ноолуур, арьс ширний агуулах барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.1.4 Мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлэх “Жавхлант сүү” төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.5 Малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.6 Малын тэжээл тариалах чиглэлээр гаргасан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын санал санаачилгыг дэмжинэ.

#### 4.2 Шударга ёсны засаглал

4.2.1 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх “Цахим Жавхлант” хөтөлбөр хэрэгжүүлж, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллана.

4.2.2 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлт, саналыг хугацаа болоогүй гэдгээр удаашруулдаг хүнд суртлыг арилгаж, цахимаар хянаж, дүгнэдэг болно.

#### 4.3 Орон нутгийн төсвийг ил тод, олон нийтийн хяналттай зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3.1 Төсвийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг хангаж иргэд, олон нийтийн оролцоотой хянах боломжийг бүрдүүлнэ.

4.3.2 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж ажиллана.

4.3.3 Татварын шинэ хуулийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

ЖАВХЛАНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

